

Төслийн тайлант хугацаа	2010 он
Төслийн нэр, код	Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төсөл, хөтөлбөр Дугаар: 42322
Хандивлагч улс, олон улсын байгууллагын нэр	Азийн Хөгжлийн Банк
Төслийн хэрэгжих хугацаа (эхлэх, дуусах огноо)	2009.01.01 - 2012.06.30
Төслийн хэрэгжих салбар	Нийгмийн хамгаалал
Төслийн хамрах хүрээ /төсөлд хамрагдах байгууллага, хот, аймаг, орон нутгийн нэгж/	Монгол Улсын нийслэл хот, 21 аймгийн бүх сумд
Төслийн хүрээнд хийгдэх ажлууд, тэдгээрийг гүйцэтгэх төлөвлөгөө /он тус бүрээр/, гол зорилтот арга хэмжээ, шалгуур үзүүлэлтүүд	<ol style="list-style-type: none"> 1. ХТХ-ийн туршилтыг хэрэгжүүлэх үе шат бүрт чадавхийг бэхжүүлэх (байнга) 2. ХТХ-ийг өргөжүүлэх, нийгмийн халамжийг шинэчлэх талаарх чадавхийг бэхжүүлэх (байнга) 3. Олон нийттэй харилцах стратегийг эцэслэн боловсруулж, хэрэгжүүлэх (2009-2011) 4. Гамшгийн үед шуурхай оновчтой хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх механизмын чадавхийг үнэлэх, бэхжүүлэх (2009 оны 6-р сар – 2011 оны 12-р сар) 5. Нийгмийн халамжийн салбарын чадавхи, институцийн үнэлгээ хийж, шаардагдах чадавхийг бэхжүүлэх (2011 оны 11-р сар) 6. Нийгэмд учирч болзошгүй эрсдлийг урьдчилан тооцох, хөнгөвчлөх, хариу арга хэмжээ авах тогтолцооны үнэлгээ хийж, чадавхийг бэхжүүлэх (2009-2010)
Төслийн хүрээнд тайлант хугацаанд /2010 / хийгдсэн ажлууд	<p>Хөтөлбөрийн хүрээнд зорилтот иргэдэд хүнсний талон олгох үйл ажиллагаа хийгдэв.</p> <p>Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох шинэ аргачилал боловсруулан батлуулж, уг аргачилалаар 4 аймаг, 1 дүүрэгт судалгаа хийж, 83 мянга гаруй өрхийн мэдээллийн сан үүсгэв.</p> <p>Тайлант хугацаанд төслийн хүрээнд нийт 5 багц зөвлөх үйлчилгээг үзүүлэх дотоодын болон гадааны зөвлөх байгууллагуудыг АХБ-ны Зөвлөх үйлчилгээ худалдан авах журмын дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн.</p> <p>Зөвлөх багц 1: Мэдээлэл сурталчилгаа. “Боролдой студи” ХХК-тай 2010 оны 2 дугаар сарын 18-нд гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Энэхүү багцын хүрээнд Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөрийн мэдээлэл сурталчилгааны стратегийг боловсруулан хэрэгжүүлэх, шаардлагатай МСС-ны материал, телевиз, радиогийн нэвтрүүлэг, шторкны эх бэлтгэх ажлуудыг хийж байна.</p> <p>Зөвлөх багц 2: Хөндлөнгийн хяналт-шинжилгээ үнэлгээ. “Мониторинг төв” ТББ-тай 2010 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Энэхүү зөвлөх үйлчилгээний хүрээнд Хүнсний талон хөтөлбөрийн хэрэгжилт болон ХТНХТ-ийн бусад үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт-шинжилгээ үнэлгээг хагас жил тутам хийж үр дүнг хөтөлбөрийн ороцогч талуудад танилцуулж байна.</p> <p>Зөвлөх багц 3: Олон нийтийн оролцоонд тулгуурлан өрхийн хүнсний аюулгүй байдлыг хангах. “Иргэдийн</p>

	<p>оролцоо нийгмийн хөгжилд” ТББ-тай 2010 оны 6 дугаар сарын 04-ний өдөр гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Энэхүү багцын хүрээнд орон нийтийн оролцоонд тулгуурласан өрхийн хүнсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон нийтийн оролцооны чадварийг бэхжүүлэх ажил хийж байна.</p> <p>Зөвлөх багц 4: Хяналт-шинжилгээ, үнэлгээ. “Оксфорд Полиси менежмент” ХХК-тай 2010 оны 12 дугаар сарын 14-нд гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Зөвлөх багц 5: Институцийн хөгжил. “Оксфорд Полиси менежмент” ХХК-тай 2010 оны 11 дүгээр сарын 05-нд гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Энэхүү багцийн хүрээнд нийт 8 хүн/сар гадаадын, 10,5 хүн/сар дотоодын зөвлөхүүд ажиллана. Зөвлөх багцын хүрээнд дараахь ажлууд хийгдэнэ, үүнд: зорилтот бүлэгт хүргэх тэтгэлэгүүдийг хүргэх төвлөрсөн бус нийгмийн халамжийн тогтолцоог бэхжүүлэх, нийгмийн зарлагын үнэлгээ болон нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн санхүүгийн тогтвортой байдал, урамшуулал ашиглан иргэний бүртгэлийг сайжруулах, нийгмийн халамжийн тогтолцооны шинэчлэл болон чадамжийг бэхжүүлэх мэдлэгийн бүтээгдэхүүн боловсруулах, зөвлөх багц 2-т дэмжлэг үзүүлэх ажил хийгдэнэ.</p>
Төслийн нийт төсөв /мян.доллараар/	3 000 000 ам.доллар
2011 онд төслийн хүрээнд хийгдэхээр төлөвлөсөн томоохон ажлууд /огноо/	<p>Бүрэлдэхүүн хэсэг 1. Хүнсний талон хөтөлбөрийн боловсруулж, хэрэгжүүлэх</p> <p>1.1.ООТАргаар Өрхийн Амьжиргааны Түвшинг тодорхойлох ажлын 2-р үе шат</p> <p>2.1.ООТАргаар Өрхийн Амьжиргааны Түвшинг тодорхойлох ажлын 3-р үе шат</p> <p>Бүрэлдэхүүн хэсэг 2. Чадавхийг бэхжүүлэх болон мэдээлэл сурталчилгааны стратеги боловсруулах</p> <p>2.1 Чадавхийг бэхжүүлэх</p> <p>2.2 Мэдээлэл, сурталчилгааны стратегийг хэрэгжүүлэх</p> <p>Бүрэлдэхүүн хэсэг 3. Нийгмийн халамжийн байгууллагын стратеги болон тогтолцоог бэхжүүлэх</p> <p>3.1. Хүнсний хямралын эсрэг тогтолцоо бүрдүүлэх</p> <p>3.2. Нийгмийн халамжийн тогтолцооны шинэчлэлийн стратегийг боловсруулах</p> <p>3.3.Нийгмийн хямралыг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоо бүрдүүлэх</p>
Төслийн 2011 оны төсөв	1 723 195 ам.доллар
Төслийн менежерийн нэр, хаяг, утас, электрон хаяг	<p>Н.Сонинтамир Хаяг: СБД, 6-р хороо, Монроимпекс 37Б, 406 тоот Утас: 323493 Электрон хаяг: soni@fnswpp.mn</p>
Төслийн хэрэгжилтэнд хяналт тавин ажилладаг төрийн байгууллагын холбогдох газар, хэлтэс, албан тушаалтны нэр, утас, электрон хаяг	<p>Д.Баттөр СЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Төслийн УЗ-ын дарга Утас: 264346 Электрон хаяг: battur@mof.gov.mn</p> <p>У.Бямбасүрэн НХХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Утас: 261973 Электрон хаяг: byambasuren@mswl.gov.mn</p>

